

2025/ 12 / 18

№ 25/26

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 12 сарын 16-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани өөрийн нийт гаргасан энгийн хувьцааны 6.99 хувьтай тэнцэх 2,000,000 ширхэг халаасны хувьцааг, нэг бүрийн үнэ 4,000 төгрөгөөр тооцож Хөвсгөл ХК-д худалдахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ, баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025/ 12 / 18

№ 25/27

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь өөрийн токенжуулсан хувьцаа болох ARDT-г олон улсын виртуал биржид гаргах ажлын зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бүх үйл ажиллагаанд оролцохыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Энэхүү ажилтай холбоотой бүх гэрээ, хэлцэл, баримт бичигт гарын үсэг зурах, бүрэн эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд **ОЛГОСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бүртгэл, шинжилгээ, үнэлгээ, хууль зүйн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, хэрэгжүүлэхийг холбогдох албад, ажилтнуудад **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025/ 12 / 18

№ 25/а8

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалаас Батбилэгийн Золбоо өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хүлээн авч, 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон, үүрэгт ажлаас нь **ЧӨЛӨӨЛСҮГЭЙ.**
2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор, Гүйцэтгэх захирлыг томилох хүртэлх хугацаанд, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх удирдлагын зарим үүргийг ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг болон компанийн менежментийн баг хэрэгжүүлэхийг тус тус **ДААЛГАСУГАЙ.**
3. Гүйцэтгэх захирлын ажил үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор ТУЗ-ийн даргыг Гүйцэтгэх захирлаар томилсон гэж үзэхгүй бөгөөд ТУЗ-ийн даргын эрх зүйн статус, үүрэг, албан тушаал хэвээр үлдэхийг **ТЭМДЭГЛЭСҮГЭЙ.**
4. ТУЗ болон компанийн менежментийн баг нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, холбогдох журамд нийцүүлэн Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж, томилох үйл явцыг шуурхай явуулахыг **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч. ГАНХУЯГ

2025/ 12 / 18

№ 25/29

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хөрөнгө оруулалт татах стратегийн хүрээнд, Сингапур Улсад бүртгэлтэй Ard Holdings International Pte. Ltd. компанитай хамтран ажиллаж, олон улсын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Компани өөрийн болон хамаарал бүхий зарим компанийн хувьцааг барьцаалахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Энэхүү тогтоолын Хавсралтад заасан хувьцааг барьцаалахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
3. Энэхүү барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн хөрөнгө оруулагчдыг татах, Ard Holdings International Pte. Ltd.-ийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын бүтцийг бэхжүүлэх, Хөрөнгө оруулагчдад холбогдох барьцаа хөрөнгийг шилжүүлэхэд чиглэгдэхийг **ТЭМДЭГЛЭСҮГЭЙ.**
4. Барьцааны гэрээ болон түүнтэй холбоотой бүхий л бичиг баримт, эрх зүйн хэлцлийг байгуулах бүрэн эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд **ОЛГОСУГАЙ.**
5. Энэхүү тогтоол гарсны дараа шаардлагатай бүх бүртгэл, шинжилгээ, үнэлгээ болон хууль зүйн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, хэрэгжүүлэхийг холбогдох албад, ажилтнуудад **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч. ГАНХУЯГ

2025/ 12 / 18

№ 25/30

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани хөрөнгөөр баталгаажсан токен гаргах зорилгоор компанийн эзэмшлийн хөрөнгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д тусгаарлуулж, тус токеныг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч Айдакс бирж дээр гаргах ажилд Ард Бит ХХК болон Ард Секюритиз ҮЦК ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралтад зааснаар хамтран ажиллахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн данснаас чөлөөлөх, шилжүүлэх үйл ажиллагааг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхийг **ДУРДСУГАЙ.**
3. Дээрх үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох гэрээ, хэлцэл, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад чиглэсэн итгэмжлэл үйлдэх, шаардлагатай баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд олгож, төлбөр тооцоог гүйцэтгэхийг Нягтлан бодогч Б.Баасансүрэнд тус тус **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч. ГАНХУЯГ